



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2017 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Г 7

Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний
хүrtтээмжийг нэмэгдүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2017 оны 216 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 1.3.1-ийг үндэслэн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний хүrtтээмжийг нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг сайжруулах, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАХ нь:

Нэг. Үйлчилгээний хүrtтээмжийг сайжруулах тухай

1. Ажлын цаг ашиглалтыг сайжруулж, амбулаторийн зарим кабинетын үйлчилгээг ажлын өдрийн 16 цаг 30 минутаас өмнө зогсоож байгаа байдалд хяналт тавьж, үйлчилгээний тасралтгүй байдлыг сайжруулах;

2. Ачаалалтай байгаа тусlamж үйлчилгээнд эмч, сувилагч нарыг сэлгэн ажиллуулж, ажлын цагийн нягтралыг сайжруулах;

3. Эмнэлгийн мэргэжилтний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зохион байгуулалтын оновчтой арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Хоёр. Төлбөртэй тусlamж үйлчилгээний тухай

4. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор амралтын өдрүүдэд төлбөртэй тусlamж, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 7 сарын 27-ний өдрийн 264/A/293 тушаалаар батлагдсан журмын дагуу оновчтой зохион байгуулах;

5. Төлбөртэй тусlamж, үйлчилгээний талаар холбогдох тушаал, шийдвэр, үйлчилгээний цагийн хуваарийг ил тод байршуулах;

6. Амралтын өдрийн төлбөртэй тусlamж, үйлчилгээг иргэн өөрийн хүсэлтээр сонгох боломж, цаг товлолт, түүний зохион байгуулалтын талаарх мэдээллийг иргэдэд ойлгомжтой хэлбэрээр хүргэх;

7. Амралтын өдрийн төлбөртэй тусlamж, үйлчилгээнээс орсон орлогыг ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах зохион байгуулалтыг хийж ажиллах;

8. Албан даалгаврын хэрэгжилт, үр дүнгийн тайланг заалт тус бүрээр, улирал тутам гаргаж тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг тус тус даалгаж байна.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

